

БОЛОВСРОЛ**АНУ-ЫН КОЛУМБЫН ИХ СУРГУУЛЬ**

Эдийн засгийн бодлогын удирдлагын магистр, 2015 оны 12-р сар

Нью-Йорк хот, АНУ

2014-2015 он

ЯПОН УЛСЫН ХАКУО ИХ СУРГУУЛЬ

Бизнесийн удирдлагын бакалвр, 2008 оны 9-р сар

Өргөмжлөл: Оны шилдэг оюутан тамирчин, 2005 он

Гадаадад суралцах: Индианагийн их сургууль Блуумингтон (2007.04-2008.05-р сар)

Точиги хот, Япон улс

2004-2008 он

ТУРШЛАГА**ОЛОН УЛСЫН ВАЛЮТЫН САН**

Ази, Номхон далайн газарт судалгааны дадлагажигч

Вашингтон хот, АНУ

2015.07-2015.09-р сар

- Монгол Улсын худалдааны томоохон түншүүдийн макро эдийн засгийн судалгаа, тэдгээрийн төлбөрийн тэнцэлд үзүүлэх эдийн засгийн үр нөлөөллийн талаарх судалгааг хийж гүйцэтгэсэн; БНХАУ-ын ДНБ 1%-иар буурах нь үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш 7.8%-иар буурахад нөлөөлнө гэсэн дүгнэлтийг холбогдох удирдлагуудад танилцуулсан.

**Монголбанк /Монгол Улсын Төв банк/
Төлбөр тооцооны газар**

Газрын захирал (2016 оноос – одоог)

Улаанбаатар хот, Монгол улс

- Үндэсний төлбөрийн системийн бодлогыг тодорхойлох;
- Холбогдох зөвшөөрлийг олгох;
- Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, шинээр төлбөрийн хэрэгсэл гаргах, төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэхтэй холбогдсон дүрэм, журам батлах, шийдвэр гаргах;
- Зөвшөөрөл авсан этгээд, түүний төлбөрийн системд хамаарах үйл ажиллагаанд хяналт тавих;
- Төлбөрийн, клирингийн болон төлбөр тооцооны систем, төлбөрийн хэрэгсэл гаргахтай холбогдох бусад үйл ажиллагааг гүйцэтгэх.

Хяналт шалгалтын газар

Зайнаас хяналт тавих хэлтэст хянан шалгагч (2012-2014 он)

2009-2014 он

- Арилжааны банкуудын улирлын тайланг хүлээн авч, эрсдлийн түвшинг үнэлэн хянан нийцүүлэлт хийх чиг үүргийг хэрэгжүүлсэн. Мөн Монголбанкны захирлуудын зөвлөлд холбогдох дүгнэлтийг танилцуулж, шаардлагатай тохиолдолд эрсдэлийг бууруулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлсэн;
- Төв банкны олон төрлийн эрсдэл, тэр дундаа хугацаа хэтэрсэн зээлийн эрсдэлийг үнэлж, эдгээр эрсдэлийг бууруулах талаар өөрийн санал санаачилга дэвшүүлж ажилласан;
- Арилжааны банкуудын үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тэдгээрийн суурь эрсдэлд үнэлгээ хийж, холбогдох дүгнэлтийг Монголбанкны захирлуудын зөвлөлд танилцуулсан;
- Арилжааны банкуудын үйл ажиллагааг БНХАУ-ын зах зээлд өргөжүүлэх зорилготой харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг боловсруулж, тухайн улсын банкны хууль, тогтоомжид дотоодын банкуудын комплайнс нийцэж байгаа эсэхэд нь үнэлгээ хийсэн.

Валют, эдийн засгийн газар

Нөөцийн мэргэжилтэн (2009-2012)

- Гадаад валютын зах зээл болон тогтмол орлоготой багцын 2.8 тэрбум ам.долларын гадаад нөөц, засгийн газрын бондын орлогыг дотоод жишиг үзүүлэлттэй харьцуулан удирдахад тусалсан: бүх хугацаанд жишиг өгөөжийг дунджаар 20 суурь пунктээр өсгөж, давуулсан;

- Макро эдийн засгийн үндэс суурь, эдийн засгийн урьдчилсан таамаглалыг боловсруулан, холбогдох дүн шинжилгээ хийсний үндсэн дээр стратеги болон тактикийн хувьд хөрөнгийн хуваарилах ажлын хэсгийн багийг ахалж, ажилласан. Удирдлагад “Bloomberg terminal” ашиглан өдөр тутмын болон долоо хоног тутмын зах зээлийн чиг хандлагын тайланг бэлтгэсэн. Арилжааны банкуудын мөрдөж буй гэмтэлтэй гадаад мөнгөн тэмдэгтийг солих журмыг санаачилж, батлуулсан;
- Монголбанкинд гадаад валют импортлох хөтөлбөрийг зохион байгуулж, хяналт тавьж ажилласан.

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

- Мэргэшсэн байдал: Бондын эрсдэлийн удирдлагын үндэс ба багц хөрөнгө оруулалтын анализ сэдэвт сургалт (Дэлхийн банкны төрийн сангийн газар); Гадаад валютын нөөцийн удирдлагын зарчим, арга хэрэгсэл, стратеги сургалт (Banque de France);
- Сайн дурын ажил: Монгол Улсын иргэдэд гадаад паспортын сунгалт, сонгогчийн бүртгэл, яаралтай тусламжийн үйлчилгээ зэрэг олон төрлийн үйлчилгээг үзүүлж, Монгол Улсад зорчиж буй гадаадын иргэдэд Вашингтон хот дахь Монгол Улсын Элчин сайдын яаманд виз мэдүүлэхэд тусалсан;
- Хэлний мэдлэг: Монгол (онц), Япон (онц), Орос (анхан), Герман (анхан)
- Сонирхол: Сагсан бөмбөгийн ОУХМ, шигшээ багийн гишүүн, Монголын сагсан бөмбөгийн холбооны Удирдах зөвлөлийн гишүүн; ММСУХ-ны гишүүн, уяач; болон “Монголд та хэрэгтэй” төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн гишүүн.